



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/764
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ГОНЧИГСҮРЭНГИЙН
БАТЧУЛУУН ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Гончигсүрэнгийн Батчулууны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Гончигсүрэнгийн Батчулууны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Гончигсүрэнгийн Батчулууны сонгуулийн мөрийн хөтөлбөр (2.. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Гончигсүрэнгийн Батчулуунд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 2 . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ГОНЧИГСҮРЭНГИЙН БАТЧУЛУУНЫ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр

Бөөрөлж

Зорилго: Өөрийн мэдлэг, туршлагыг сум орон нутгийн хөгжилд зориулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.

Нэг.Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх тухай

1.Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зөв зарцуулахад хяналт тавих, төсвийн тухай хуулийн дагуу хийх.

2.Орон нутгийн орлогын зарцуулалтыг оновчтой болгох, хуучирсан эд зүйл техник хэрэгсэл худалдан авахыг зогсоох.

Хоёр.Газрын тухай

1.Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, МАА-н хоршоололд өмчлүүлэх, эзэмшүүлэхийн төлөө өөрийн санал санаачлага, иргэдийн саналыг тусгаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.


2.Тариалангийн талбайн эзэмшүүлсэн талбайн хэмжээнд тулгалт хийж хуулийн дагуу хяналт тавина.

Гурав.Ойн тухай

1.Иргэн, аж ахуйн нэгжид хэрэглээний модны хуваарилалтад хяналт тавьж хуулийн дагуу ажиллуулна.

2.Нөхөрлөлийг идэвхжүүлэх хуулийн дагуу урамшуулалтай болгох. Ойн менежментийн төлөвлөгөөтэй болгуулах.

Дөрөв.Орон нутгийн өмчийн талаар




З. Д. Д. Д.

00000000001

1.Орон нутгийн өмчид тооллого хийлгэж ашиглалт хамгаалалтыг сайжруулах, бүрэн бүтэн байлгахад хяналт тавьж ажиллах.

2.Усан цахилгаан станцыг сумын орон нутгийн өмчид авахуулж ашиглалтанд оруулах.

Тав.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хяналт тавина.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

1 ДҮГЭЭР БАГИЙН ИРГЭН

Г.БАТЧУЛУУН

3. 0000000002